



НОГООН СУУЦ БУЮУ АЛБАН БУС БАРИЛГЫН САЛБАРЫГ ЧАНАРЖУУЛАХУЙ

Хэдийгээр барилгын салбарт чанарын хяналтын систем тодорхой хэмжээгээр сайжирч байгаа хэдий ч хувийн орон сууц энэ асуудлаас хол хөндий байсаар удаж байна. Нэг талаасаа хувь хүн өөртөө ямар сууц барих нь тэр хүний асуудал мэт боловч тухайн өрхийн иргэд цаашлаад тухайн сууцыг дараа нь худалдан авах хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүднээс амины орон сууцанд чанарын шаардлага зайлшгүй, албан ёсоор тавигдах ёстой гэж үзэж байна. Өөр нэг асуудал нь агаарын бохирдол. Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд өнөөдөр агаарын бохирдол гамшгийн хэмжээнд хүрээд байгаа бөгөөд голлох шалтгааныг гэр хороолол гэж үздэг.

Гэр хорооллын сууцны бүтцийг аваад үзэхэд Улаанбаатар хотод 2004 онд 56,2 мянган гэр, 61,4 (52 хувь) мянган жижиг хувийн орон сууц байсан бол 2011 онд 81,6 мянган гэр 100,3 (55 хувь) мянган жижиг хувийн орон сууцтай болсон байжээ. Эндээс үзэхэд жилд дунджаар 5000 хувийн сууц Улаанбаатар хотод баригдаж байгаагийн дийлэнхи нь гэр хороололд байна. Хүн амын амжиргааны түвшинтэй уялдаад энэ тоо сүүлийн жилүүдэд улам ч хурдацтай нэмэгдэж байна.



Гэр хорооллын түгээмэл төрх.



"Жаргалант эко" хувийн орон сууцны хороолол

Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам хамтран хэрэгжүүлж байгаа Барилгын эрчим хүч хэмнэлтийн МОН/09/301 төслөөс иргэдийг өнөөгийн барилгын салбарт мөрдөгдөж буй норм стандартын шаардлагад нийцсэн сууцтай болоход дэмжлэг үзүүлэх

үүднээс "НОГООН СУУЦ" хөтөлбөрийг хэрэгжүүлэн Хас банк, Монгол дахь мянганы сорилтын сангийн Цэвэр агаар төсөлтэй хамтран ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь иргэд өнөөдөр барилгын стандартад нийцсэн хувийн орон сууц барих хүсэл сонирхолыг бий болгох явдал юм. Энэ хүрээнд дараах үйл ажиллагаануудыг явуулж байна.

Чанартай барилга барих хамгийн эхний алхам бол зураг төсөл байдаг. Төслөөс дулаалгатай хавтгайлжин бүтээц, дулаалгатай өргөт бүтээц, модон арагт бүтээц, гэсэн технологийн шийдэл бүхий нийт 21 төрлийн 35-90 м² талбайтай хувийн орон сууцны нэг маягийн ажлын зургийг иргэдэд зориулан боловсруулсан бөгөөд хүссэн иргэн үнэгүй авч ашиглах боломжтой.



БАРИЛГЫН ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ПАСПОРТ

Барилгын нэр, төрөл	Хувийн орон сууц (Барилгын)						
Барилгын эзэмшэгч							
<table border="1"> <tr> <td>А</td> <td>В</td> </tr> <tr> <td>С</td> <td>Д</td> </tr> <tr> <td>Е</td> <td>Ж</td> </tr> </table>		А	В	С	Д	Е	Ж
А	В						
С	Д						
Е	Ж						
Барилгын халаагчийн дулааны эерхийн хувийн төсөрлөх зарцуулалт, Вт (кВт/С.м ²)	26,0						
Барилгын халаагчийн дулааны эерхийн хувийн өөрчлөх зарцуулалт, Вт (кВт/С.м ²)	30						
А	19,11						
В	19,21						
С	23,2						
Д	41,05						
Е	68,56						
Ж	<						
Нарийвчилсан шаардлагад барилгын зургийг төсөл төсөл байгаа эсэх	Тайв						
Барилганд зургийг төсөлийн дагуу төсөл төсөл эсэх	Үгүй						
Олгосон байгуулагч	Барилгын эрчим хүч хэмнэлтийн төсөл						



Барилганд шогшо олгосон байдал болон эрчим хүчний паспортын хэсэг.

Иргэдэд олгож байгаа бас нэг боломж бол технологийн гарын авлага, видео материалууд юм. Зөвхөн иргэд ч бус барилгын салбарын ажилтан, ажилчид ч эндээс барилгын технологийн талаарх мэдээллүүдийг олж авч ашиглах боломжтой. Иргэд болон барилгын салбарынханд зориулсан сургалтуудыг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад байрлах эрчим хүч хэмнэлтийн төвүүдээр дамжуулан тогтмол явуулж байна.

Та бүхэн энэ талаархи дэлгэрэнгүй мэдээллийг авахыг хүсвэл

www.beep.mn

вэб хуудсанд хандаарай. Албан бус гэж тодорхойлогдог хувийн орон сууцанд чанарын тогтолцоог нэвтрүүлэхэд төслийн зүгээс анхдагч алхамуудыг хийж эхлээд байгаа бөгөөд цаашид илүү өргөн хүрээний ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Дараагийн удаад эрчим хүчний хэмнэлттэй хувийн орон сууцанд үзүүлж байгаа санхүүгийн дэмжлэгийн талаар танилцуулах болно.



Модон араг бүтээцтэй барилгын зураг төслийн хэсэгт

Тухайн иргэн батлагдсан зураг төслийн дагуу хувийн орон сууцаа бариулж байгаа нөхцөлд захиалагчийн зүгээс тавих хяналтын зардлыг төслөөс санхүүжүүлэн гүйцэтгүүлж байна. Агаарын бохирдлыг

бууруулах арга хэмжээний хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй технологийг нийлүүлэгч болоод хэрэглэгчийг дэмжих тухай зүйл, заалт «Агаарын тухай» багц хуульд тусгагдсан бөгөөд барилгын хувьд үүнийг баталгаажуулах гол баримт нь барилгын эрчим хүчний паспорт юм. БНБД 23-02-2009 "Барилгын дулаан хамгаалалт" –нд заагдсаны дагуу барилгын эрчим хүчний хэрэглээгээр ангилж паспортжуулахаар заасан бөгөөд үүнийг хэрэгжүүлэх хүрээнд төслөөс НОГООН СУУЦ шогшгыг эрчим хүчний хэмнэлтийн ангилалын А болон В ангилалд нийцсэн барилгуудад олгож эхлээд байна. Төсөлд хамрагдаж байгаа сууцнуудад энэ төрлийн үйлчилгээг үнэгүй үзүүлж байгаа болно.